

## ОРЧИН ҮЕИЙН УРЛАГИЙН ФИЛОСОФИД Ж-П.САРТР, А.КАМЮ НАРЫН ЭЗЛЭХ БАЙРЬ СУУРЬ

**Түлхүүр үг:** Урлагийн философи, интуитивист гоо зүй, экзистенциализм, хүний гоо сайхны мэдрэмж, хүний эрх чөлөө, сонголт, хариуцлага, хариуцлагаа ухамсарлах, айдас, цөхрөл, хайр, үзэн ядахуй.

**Товч утга:** Зохиогч энэхүү өгүүлэлдээ орчин үеийн урлагийн онолын асуудлыг экзистенциалист философийн үүднээс авч үзэх зорилго тавьсан. Энэ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд нэрт экзистенциалист философч Сартр, Камю нарын философи баримтлалуудыг онцолж, тэдгээрийг орчин үеийн урлагийн онолын тулгамдсан асуудлуудтай холбон авч үзэх оролдлого хийсэн болно.

Экзистенциализмыг гол төлөв оршихуйн философи гэж нэрлэдэг билээ. Энэ философийн үүднээс хүн амьдралынхаа эхэн үед бүрэн чөлөөтэй байж, ямар нэгэн зүйлд зориулагдан, өөрийн сонголтоо чөлөөтэй хийж, өөрөө өөрийгөө төлөвшүүлдэг учраас экзистенциализмын ийм урьдчилсан үндэслэл чухал ач холбогдолтой байдаг. Экзистенциалист философи ба экзистенциалист урлагт эрх чөлөөний асуудал бол нэн чухал асуудал мөн. Аливаа хүн өөрийн амьдралын замаа эхлэх явцдаа өөрөө өөрийгөө төлөвшүүлэн бүтээх зорилгоо тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байдаг. Гэхдээ энэхүү философийн үүднээс оршихуй нь мөн чанараа тодорхойлдог учраас нэг үндсэн баримтлал нь хүн өөрийн оршихуйг хариуцах тухай үзэл мөн. Өөрөөр хэлбэл хүн ямар нэг урьдчилан тааварлахын аргагүй буюу төрөлхийн гажигт амьдралынхаа аль нэг талыг хамруулах эрхгүй гэсэн үг юм. Аливаа шашин, эсвэл жирийн амьдралын ёс зүй хүн юу хийхийг заадаггүй учраас хүн бүрэн эрх чөлөөтэй бүтээгдэхүүн юм. Чухамхүү ийм үзэл баримтлалыг францын экзистенциалист философийг үндэслэгчийн нэг Жан Поль Сартр (1905-1980) хөгжүүлсэн байна. Түүний энэхүү баримтлалын гол санаа нь "Би өөрөө өөрийгөө сонгосноороо ер нь хүн гэсэн дүр төрхийг сонгож байгаа юм. Өөрөөр хэлбэл би өөрийн хүсэл эрмэлзлээр сонгож авсан тодорхой хүний дүр төрхийг бүтээж байна" гэсэн үг хэмээн хэлсэнд оршино. Түүнийхээр ёс суртахууны сонголт бол аливаа

хийсвэр хэм хэмжээнд суурилсан сонголт бус харин нөхцөл байдалд суурилсан сонголт юм. Энд хүний субъектив шинж чанараас өөр ямар ч шалгуур оршдоггүй. Хүний амьдралын нэг зорилго бол өөрийн субъектив шинж чанараа гүнзгийрүүлж, өргөжүүлж, хэрэгжүүлэх явдал мөн.

Хүний эрх чөлөөний хил хязгаарын тухай Сартрын үзэл санаа нь нэг нөхцөл байдлын хүрээнд хоёр эрх чөлөө зэрэгцэн оршиж чадахгүй гэсэн пессимист байр сууринд түүнийг хүргэсэн байна. Энэ нь хүн бүр харилцан бие биеэ объект болгодог учир ертөнц дээр хүмүүс бие биенээсээ дэндүү хөндий оршдог тухай ярихад Сартрыг хүргэжээ. Үүнийгээ Сартр хайртай хүнийх нь эрх чөлөө жинхэнэ эрх чөлөө бус харин түүний эрх чөлөөнд сайн дураараа орж ирсэн нөлөөлөл болохыг үргэлж эрэлхийлдэг дурлалт хосуудаар жишээ татсан байна. Түүнийхээр бусад хосуудыг ч мөн ингэж үздэг. Хүн бүр бусад хүний хүсэл зоригтой тулгарсан тэр зааг дээр өөрийн эрх чөлөөний хязгаарыг олж хардаг байна.

Ж.П.Сартр ёс суртахууны эдгээр үзлийнхээ үүднээс өөрийн үеийн шинэхэн чиглэлүүдэд шүүмжлэлтэй хандсан ажээ. Тэрээр бичихдээ “зовлонгийн дуудлага бол энэхүү зовлонг бий болгож буй дохио тэмдэг юм. Гэхдээ энэхүү дуудлага бас өөрөө зовлон гунигийг ч илэрхийлдэг” гээд эндээсээ уран сайхны бодит байдал нь өөрөө өөрөөсөө илүү гарсан бодит байдал маягаар сэтгэгдэнэ” хэмээн дүгнэсэн байна. Үүний зэрэгцээ Сартр “дүрслэн бодохуй нь ертөнцийн үндсэн фон дээр явагдах бөгөөд энэхүү дүрслэн бодохуйтай гацах нь ухамсрыг унтрааж, эцэст нь үхэлд хүргэдэг” хэмээн тэмдэглэсэн байна. Энэ нь дүрслэн бодохуйн туршлагыг хуримтлуулсан хүн үйл ажиллагаа явуулахын тулд энэ нөхцөл байдлаасаа гарах хэрэгтэй гэсэн үг юм. Чухам ийм учраас уран бүтээлчид өөрийн ухамсрын эрх чөлөөний хүрээнд бусдын ухамсрын хүрээнээс халин гарсан бүтээл туурвидаг байна. Үүнээс гадна ертөнцийн ямар нэгэн талыг чи илэрхийлэх гэж байна, чи өөрийн уран бүтээлээрээ ертөнцөд ямар өөрчлөлт оруулах гэж байна гэх зэрэг уран бүтээлчийн өөрийн хариуцлагаа ухамсарлах үйлдэл чухал ач холбогдолтой. Түүнийхээр уран бүтээлчийн үг бол буудах үедээ ярьдаг цэнэгтэй буу юм. Ямар нэг талыг уран бүтээлээрээ эзэмдэнэ гэдэг нь аливааг өөрчлөх хүсэл зориг бий болсон үед хэрэгждэг. Харин нийгэм ба хүний ямар ч өө сэвгүй дүр зургийг гаргана гэж байхгүй. Иймд Сартр “торонд хашигдсан” уран бүтээлч гэсэн онолыг үндэслэсэн байна.

Түүнийхээр уран бүтээлч оршин буй нөхцөл байдалдаа хашигдан торонд орсон мэт болдог. Ийм нөхцөлд уран бүтээлч нь хүний амьдралын бүхий л цухалдал, түгшүүр, ганцаардлыг амсаж, өөрийн айдас, хүсэл, гутрал, баяр хөөр, үзэн ядалт, уур уцаараа илэрхийлдэг. Чухам ийм давчуу орчинд л түүнд уран бүтээл туурвих хүсэл эрмэлзэл төрдөг. Уран бүтээлийн зорилго бол Сартрынхаар олон түмэнд мэдээлэл хүргэх явдал бөгөөд уран бүтээлч уламжлалт арга барилаараа уран цэцэн үгээр санаа бодлоо илэрхийлсэн бол хэзээ ч зорилгодоо хүрдэггүй байна. Ж.П.Сартр Франкфуртын сургуулийнхантай урлаг, гоо сайхны хүрээнд санал нийлдэг байсан. Ингэснээрээ урлаг гэдэг нь сэтгэл санааг аюулгүй болгодог ямар нэг арга барилуудын нэгдэл мөн гэсэн тодорхойлолтыг баримталдаг орчин үеийн урлагийн чиглэлийг эрчимтэй шүүмжилж байв. Түүнийхээр философчид бол тухайн үеийнхээ урлагийн төрлүүд нийгмийн ямар үүрэгтэйг судалж, уран бүтээл дэхь интуитив онолуудыг шүүмжлэх ёстой.

Ж.П.Сартрын урлагийн философийн салбарт баримталж байсан олон асуудалтай францын философч, зохиолч Альбер Камю (1913-1960) санал нийлдэг. "Утга учиргүй байдлын бохирдсон агаарын" нөхцөлд үйл явдал ухамсарт баттай хадгалагдах боломжийг хүнд урлаг өгдөг хэмээн тэрээр үзэж байв. Түүнийхээр бол урлаг нь агуу том пантомима буюу үггүй жүжиг юм. Учир нь урлаг нь эцсийн дүндээ урьд өмнө нь бидэнд мэдэгдэж үнэнийг дүрээр сэргээж өгдөг байна. Үүнийхээ хүчинд урлаг нь утгагүйгээс (абсурд) зугтаах, хоргодох байр бус, харин өөрөө хүний зовлон зүдгүүрийн нэг илэрхийлэл болдог. Үүний зэрэгцээ урлагийн бүтээлийн давуу тал, үнэт шинж нь тэрээр бидний оюун ухааныг хил хязгаарын нь гадна гаргаж, биднийг бусадтай шууд нүүр тулсан байдалд аваачдаг. Энэ нь Камюгийнхаар "өөрийгөө бусдын өмнө доош нь хийхийн тулд бус, харин бид хамтдаа орчихоод байгаа амьдралын замналынхаа гарцгүй болохыг" ухаарахын тулд хийж байгаа алхам юм. Иймд урлаг гэдэг нь ертөнцийн тухай хүний төсөөлөл туйлын утга учиргүй болохыг шууд заадаг байна.

Энэ шалтгааны улмаас урлагийн аливаа бүтээл нь үхлийг тодорхойлох тэмдэг болохын зэрэгцээ туршлага хуримтлуулах хэрэгсэл болдог хэмээн А.Камю үзсэн байна. Түүнийхээр урлаг нь оюун дүгнэлт алга болж, түүний оронд утга учиргүй, абсурд, хүсэл зорилго гарч ирсэн тохиолдолд ил гарч ирдэг. Гэхдээ уран бүтээлч бол ухамсар дахь ээдрээтэй үзэгдлийг шууд



утгаар нь хэрэглэдэггүй. Түүнийхээр урлагийн бүтээл нь оюун ухаан тодорхойг тайлбарлахаас зайлсхийсэн үед бий болох ба үүний үр дүнд ямар нэг хуурамч харагдах байдал үүсдэг байна. Үүнийг А.Камю "ертөнц ямар ч хиргүй тунгалаг байсан бол урлаг гээч юм бий болохгүй байсан гэж" тайлбарласан. Аливаа уран бүтээлч бол ямар нэг тайлбарлах зарчим ашиггүй гэдгийг ухамсарладаг тул урлагийн хамгийн хүчтэй тал нь тайлбарлахад бус, харин өөрийн далд утгатай илэрхийлэл, нууцлаг нөлөөллөөрөө хүн болон хүний туршлагын хоорондын зохицлын үндэс суурийг тогтооход оршдог гэж А.Камю үзжээ.

Урлагийн бүтээлийн мөнхийн эрэл хайгуул нь мухардаж, бахардсан хүний дотоодын хурц хөдөлгөөнийг сааруулж, өөртөө итгэх итгэлийг төлөвшүүлж байдаг гэж А.Камю үзжээ. Ийнхүү хүрээлэн буй орчиндоо хүн өөрийн боломжоо мэдэрсэнээр өөрийн дүр төрхөө хадгалж чадна. Эцсийн дүндээ хүн үргэлж хожигдож байдаг боловч нэр төртэй хожигдох хэрэгтэй. Үүнд нь урлаг тусалдаг хэмээн энэ философич үздэг.

### Резюме

XX век являет в искусстве принципиально новую ситуацию, которую определить как разомкнутое, открытое, неклассическое восприятие мира. Если предшествующие стилевые формы, направления, течения ранее так или иначе основывались на ограниченном эстетическом принципе, то XX век пускается в открытое плавание, где нет проложенных путей. Столь же многоликими, непохожими и парадоксальными в прошедшем столетии оказывается экзистенциалистический подход к искусству, представленный философом А.Сартром и А.Камю. В эстетике и философии экзистенциализма современникам импонировало внимание к индивиду, стремление рассмотреть и понять феномен искусства в связи с судьбами человека в современном мире, с теми изменениями, которые претерпевает природа индивидуальности. Все это характеризует экзистенциализм не только как философию свободы, но и как философию пессимизма. Поэтому он вызывает определенно сильный интерес к проблеме личности, к чему посвящена данная статья.

### Ном зүй

1. Кравцун О.А. Эстетика. М., 2000.
2. Горелов А.А. Философия. М., 2000.
3. Камю.А. Миф о Сизифе (главы: "Абсурдное рассуждение" и "Абсурдное творчество") // Сумерки богов. М., 1990.
4. Сартр.Ж.П. Экзистенциализм – это гуманизм // Сумерки богов. М., 1990.
5. Философия. М., 2003.
6. Философия. /сурах бичиг/ УБ., 2002.
7. Радугин А.А. Гоо зүй. УБ., 2002. и

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ

Эрдэм шинжилгээний бичиг

№ 244 (27)

**Редакцийн зөвлөл:**

Доктор Ш.Содном (ерөнхий эрхлэгч)

Доктор Г.Лувсанцэрэн (эрхлэгч)

Доктор (Sc.D) Ц.Гомбосүрэн (орлогч эрхлэгч)

Доктор Р.Дарьхүү (нарийн бичгийн дарга)

**Гишүүд:**

Доктор С. Норовсамбуу (академич)

Доктор (Sc.D) Н.Хавх (проф)

Доктор М.Отгонбаяр (проф)

Доктор С.Цэдэндамба (дэд проф)

Доктор М.Гантуяа (дэд проф)

Хэвлэлд бэлтгэсэн: Т.Энхтунгалаг

Цаасны хэмжээ: 1/8

Хэвлэлийн хуудас: 21

Хэвлэсэн тоо: 200

МУИС-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.